# “Дүлий байдлаас Эдгэрэл олох нь Аз аргал юм”

Хүмүүсийн амьдралд дуу чимээ эсвэл осолоос болж дүлийрэх, чихний үрэвсэл (чихтэс), чихэнд сонсогдох дуу чимээний өвчинг багтаадаг сонсголын чадвар дутуу хүмүүсийн тоо байгаа юм. Сонсгол нь гэмтсэний дараа эдгэрэхэд хэцүү байдаг учраас бид чихээ сайн хамгаалах хэрэгтэй. Доктор И Жэе рукээр дамжуулан Бурханы эрх мэдэлт хүч с илүү хурдан илэрхийлэгдэж, зарим өвчтэй гишүүд цуглааны үеэр эдгээлтийг хүлээн авсан бөгөөд олон гайхамшгууд тохиолдсон билээ. Энэ нь Бурханы хүчийг харуулсан сонсголын эрхтэн эдгээрлдийн талаар юм.

## “Цуглааны дундуур, Би Сургаалыг тодоор онсож хэлсэн”

Мяунг-яуп Рюу
(Гэрэл ба Давс Номлолын Бүлгийн 1-р салбарn)



1990-өөд оны үед даавууны үйлдвэрт ажиллаж байхдаа машины чанга дуу чимээнээс болж миний чихэнд чимээ чангаар сонсогдож эхэлсэнийг би мэдэрсэн. Тус өдрөөс эхлэн ус шиг наалдамхай бодис чихнээс гарч цустай, идээтэй шингэн гарах болсон. Хажууд байсан хүмүүсийн яриаг сонсож чадахгүй ч амьдрахын эрхээр тэвчих хэрэгтэй байв. Тэгээд дэлгүүрт ажиллаж эхэлсэн боловч үйлчлүүлэгч нартай харилцахад хэцүү байв.

2007 онд чих, хамар, хоолойн эмчид үзүүлэхэд эмч намайг сонсголын аппарат зүүхийг санал болгов. Би үнэн сэтгэлээсээ сонсмоор байсан ч, гадаад төрх байдалын улмаас сонсголын аппарат зүүмээргүй байв. би ажиллахдаа олон хэцүү зүйлтэй тулгарч байлаа. Үйлчлүүлэгчтэй ярилцахад хэрэглэгчдийн амны хайрцаг харах тоолонд миний нурууны хүйтэн хөлс гоождог байв. Би утас авч харилцахаасаа ч айдаг болсон байв.

Түүнээс ч илүү хэцүү чихэнд сонсогдох элдэв чимээний өвчтэй байсны улмаас миний чихэнд сонсогдох дүнгэнэх чимээнээс болоод шөнө сайн унтаж чаддаггүй байв. Өдрөөс өдөрт өвдөлтөөс өвдөлтийг улам мэдрэв. Би Христч амьдралдаа хайхрамжгүй хандаж ертөнцийн амьдрал руу явж байв. Би зөвхөн бүтэн сайн өдөр сүм рүү явдаг байсан бөгөөд аравны нэгээ өргөдөггүй байв. Би телевизийн програмуудыг үзсэнээрээ амьдралд минь байсан гансралаа дүүргэхийг хүсч байв. Миний өвдөг маань үе мөчний үрэвсэлтэй байсан болохоор ажиллахаа болихоос өөр аргагүй болж хийх зүйл надад байхгүй байсан юм.

2009 оны 11 сарын 1-нд, Гэрэл ба Давсны бүлгийн удирдах Пастор над дээр айлчилан ирсэний дараа, би итгэлгүй Христч бус амьдралаар амьдарч байснаа ухаарч Тэргүүн Пастор дээр ирж залбиралыг нь хүлээн авсан. Маргаашнаас нь би хоёр удаагийн Онцгой Даниел Залбиралын Цуглаан, Өвчин Эдгээлтийн Цуглаанд (Манмин Залбиралын Төв) өдөр болгон очиж, өөрийн хийсэн буруу зүйлээсээ нулимсаа асгаруулан гүнээ гэмшиж залбирсаны эцэст Бурханы үгээр амьдарч цугларалт бүрт очих зүтгэлийн минь хариуд, Бурхан миний өвдөгийн үе мөчний үрэвслээс эдгэрэлийг өгсөн.

Би үргэлжлүүлэн Бурханы хайрыг мэдэрч ирсэн. Өнгөрсөн 1 сарын 31-нд Бүтэн сайны өглөөний мөргөлийн дундуур, сургаалаар дамжуулан би их энэрэл ивээлийг хүлээн аван “амен” хэмээн нулимсаа асгаруулав. Сургаал дуусахад, би номлогчыг илүү тодоор сонсож эхлэв. Би хэн нэгний дууг нь чангаласан гэж бодсон учраас би “Тэд чангаласан юм уу? Маш сайн сонсогдож байна!” гэж хажуу дахь хүнээсээ асуусан. Тэр, “Тийм үү? Надад яг адилхан сонсогдож байна,” гэж хариулж билээ.

Тэр цаг мөчид ужиг чихтэс минь эдгэрсэн бөгөөд би сонсгол сайтай болсоноо мэдэрлээ. Би намуухан дуу чимээнүүдийг сонсоход хэцүү байсан, гэхдээ тэр мөчөөс хойш би намуухан дуунуудыг ч сонсож чаддаг болсон юм. Би Бурхандаа алдарыг өргөн залбирч өгсөн Тэргүүн Пастортаа аугаа хайраар талархалаа илэрхийлмээр байна.

## “Одоо би сонсголын аппаратгүй сонсож чадна”

Сүмд үйлчлэгч Чион Ёнг рэй
(5-2 Эмэгтэйчүүдийн багийн 8-р хэсэг)



Би бага байхдаа горхинд унаж осолдсоноос хойш баруун чих маань 25-н жилийн туршид сайн сонсож чадахаа байсан. Түүнээс ч илүү хүнд хэцүү нь 6-н жилийн өмнө нэг хүн миний хацар уруу алгадсанаас, зүүн чихнээс булга гоожин сонсгол улам муудаж сонсголын аппарат зүүх шаардлагатай болов.

Сонсгол муутай байсан ч, би олон жилийн туршид Манмин Мэдээг олонд тунхаглан авралын зар түгээдэг байсан. Хэдэн сарын өмнөөс эхлэн би Хэсгийн Удирдагч сүмд үйлчлэгч Шин Сонг хий-гийн тусламжтайгаар долоо хоногт 1000 ширхэгийг тараадаг байв. 1 сарын 22-ын 5 дахь өдрийн оройн мөргөлийн өмнө сонсголын эдгээлтийн залбиралыг Тэргүүн Пастораас хүлээн авав. Маргааш өглөө нь сонсголын аппарат зүүсэн хэдий ч аппаратгүйгээр сайн сонсож буйгаа мэдэрсэн.

## “Би илүү сайн сонсож чадах болсноор амьдрал минь илүү аз жаргалтай байна”

Чой Ах
(Хойд Солонгосын Дүрвэгсдийн 27-р хэсэг Салбар)



1951 онд Солонгосын дайнд би 16 настай Солонгосын цэрэгт тусалж байлаа. Би баригдаж Хойд Солонгосын Цэрэгт олзлогдов. Хүмүүс намайг тагнуулч гэж буруу ойлгосоноос аймшигт тамлалтыг тэвчин, олон удаа зодуулсан ч давж гарсан. Үүнээс болоод миний чихний хэнгэрэг гэмтэн би сайн сонсож чадахгүй болсон.

2003 онд, би Хойд Солонгосоос дүрвэн гарав. Сонсгол муу, бас бүхийл зүйлсээс айдас хүйдэстэй байв. Христч амьдралдаа сонирхолгүй болж олон сарын турш сүмд очоогүй тийм цаг хугацаа байсан юм. Саяханаас би сүмдээ очин хэвшиж эхэлсэн. Өнгөрсөн 1 сарын 29-нд би Хойд Солонгосын Дүрвэгсдийн багын бусад гишүүдтэй хамт, улсын гаъяаны шагналуудыг хүлээн авахаар Тэргүүн Пасторын залбиралыг хүлээн авав. Миний гайхлыг төрүүлсэн нэгэн зүйл нь 1 сарын 31-ний Эзэний өдрийн сайны өглөөний мөргөлийн Тэргүүн Пасторын сургаалыг маш тодоор сонсож эхлэв. Би сонсголын эдгээлтийн залбиралыг хүлээн аваагүй ч гэсэн, Бурхан энэ мөргөлийн дундуур намайг эдгээсэн. Бурхан үнэхээр амьд. Миний амьдрал сайн сонсголтойгоор илүү аз жаргалтай байна.

## “Би хүсэлгүйгээр амьдарч байсан, мөн нэгэн Гайхамшиг Надад Тохиолдсон”

Мюунгсун Парк Эгч
(Чайнг-Вон Манмин Сүм)



Нэг жилийн өмнө миний өвдөгөнд хиймэл үе суулгах мэс заслаас болж би их удаан хугацаагаар эмнэлэгт хэвтсэн. Түүнээс хойш, хоёр чих минь сонсголоо алдаж сайн сонсож чадахгүй болсон юм.

Миний бие маш их өвдөн шаналж байхад сайн мэдээ тунхаглагч нэг хүн над дээр ирсэн юм. Тэр нь сүмийн халамжлагч Чо Мюнг соо байсан. Би Чайнг-Вон Манмин Сүмд очиж эхлэв. Гэр маань сүмээс нэг цагын зайтай байсан ч би хичээнгүйлэн цуглаанд очиж итгэлтэйгээр Бурханы хүчээр эдгээлтийг хүлээн авахыг хичээв. Өнгөрсөн 1 сарын 29-нд би Өвчиний дгэрэлийн цуглаанд Сөүл рүү яваад Тэргүүн Пасторын залбиралыг нь хүлээн авсан. Чайнг-Вон руу буцах замд машин дотор нэгэн гайхамшигт зүйл тохиолдов. Хэн нэгэн миний чихэнд ойрхон ярихад сонсож чаддаг байв. Гэтэл гэнэт би сонсголын аппаратгүйгээр ч намуухан дуу чимээнүүдийг сонсож чаддаг болсон байлаа. ХАЛЕЛУЯА!

### Бурханы Хүч рүү Чиглүүлэх нь

Угийн сохор мөн сонсголгүй байдал орчин үеийн анагаах ухааны судлалаар эдгээгдэшгүй байгаа юм. Хэрвээ бид итгэлээр Бүтээгч Бурханы хүчийг гуйх юм бол бид Библи дээрхийн адил орчин үед ч тохиолдож буй гайхамшгуудыг үзэж чадна (Еврей 13:8; Ефес 4:13). Хэрэв ухэжсэн, эсвэл муудсан мэдрэлийн эсүүд сэргээгдэх бол, төрөлхийн сохор хүн хардаг болох, эсвэл дүлий хүн сонсдог болох бол бид Есүс Христчийн итгэлийн хэмжээнд хүрсэн итгэлтэй хүнээр дамжуулан Бурханы хүчээр эдгээгдсэн хэмээн төгс хэлж чадна.

*- Ер Бусын Гайхамшгуудын (Дахин Бүтээхийн Хүч) 3-р Бүлгээс авагдсан*

### Мөргөлийн цаг

| Мөргөл | Цаг |
|---|---|
| Их мөргөл | Ням гариг 10: 30 |
| Үдээс хойшх мөргөл | Ням гариг 13: 40 |
| 3-дахь өдрийн мөргөл | 3 дахь өдөр 18: 00 |
| 5-дахь өдрийн мөргөл | 5 дахь өдөр 22: 00 |
| Хүүхдийн мөргөл | ням гариг 10: 30 |
| Сурагч залуучуудын мөргөл | Хагас сайн өдөр 16: 30 |

### Залбирлын цаг

| Ангилал | Цаг | Удирдагч |
|---|---|---|
| Даниел үүрийн залбирал | Даваа- баасан 05: 00- 06: 00 | Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч) |
| Даниел өдрийн залбирал | Даваа- баасан 09: 00- 10: 00 | П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч) |
| Даниел оройн залбирал | Өдөр бүр 18: 30- 20: 00 | П. Батзориг (Чуулганы хариуцагч) |




Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.or.kr
www.manmintv.org

Манмин Мэдээ

NO. 4 2010 оны 4 дүгээр сар 11

# “Хөршөө өөрийн адил хайрла”

## гэх сургаалыг хэрэгжүүлэх Манмин Сүмийн Гишүүдийн Эрэмгий Зориг болон Сайн Үйлс:

Гымчеон Цагдаагийн Газар дахь Мөнсунг бүст хамаарагдах ахмад Чайнг Мяунгсуп гэгч 3 сарын 22-нд манай сүмд элссэн юм. Түүнийг урсан сүмд үйлчлэгч Ким Суу, “Тэр маш итгэлтэй итгэгч юм,” гэж хэлэв. Түүний цагдаагийн ажил нь түүнээс өндөр хариуцлага шаарддаг ч гэсэн, Чайнг Бурханы үгийн дагуу амьдрахын тулд итгэлийн үйлчилэлд хичээнгүйлэн зүтгэдэг.






Өнгөрсөн 10 сарын 8нд KBS-ээр (Солонгосын Нэвтрүүлэгийн Систем)/ нэвтрүүлэгдсэнчлэн мэдээ” гал дунд орсон цагдаагийн Офицер” гэсэн гарчигтайгаар Чайнг Мюнг супын (баруун талд, эмнэлэгийн хувцас өмсөж буй) зоригтой үйлийн тухай мэдээллэсэн байв. Чайнг тус иргэнийг аврахдаа хортой утаагаар амьсгалсан байсан бөгөөд 3 өдрийн турш эмнэлэгт хэвтсэн юм. Тэр нэг эмнэлэгт эмчлүүлэхдээ тэр эмээгийн биеийн байдалыг шалгадаг байв.

Өөрийн гэр бүлд итгэлтэй байх байдал болон гүнзгий итгэлийн улмаас Манмин сүмийн гишүүдэд нэр хүндтэй юм. Тэдний айл саахалтын хүмүүс ч тэднийг сайн үйлсүүдийнх нь төлөө ам сайтай байдаг. “Гымчеон Цагдаагийн Газарт ажилладаг офицер Чайнг Мяунгсуп (40) өрөөндөө ухаан алдсан байсан И эмээг аварч амжсан юм. Утаа мөн дөлөөр дүүрсэн өрөөнд нь орох гэсэн олон оролдлогын дараа, тэр ойролцоогоор 10 минутын дотор түүнийг авч гаргаж амжсан” гэдгийг Ёнхапын Мэдээ 10 сарын 7-нд нийтлэгдсэн байсан.

Чайнг тэр газарт дуудлагаар ирэхэд, “пат”-хийн чанга тэсрэн, утаа, гал дөлөөр дүүрсэн байв.” Утаагаар дүүрэн өрөөнд юу ч харагдахгүй байв. Гэхдээ тэр хүн ёолж буйг сонссон учраас түүний бодох ганцхан зүйл энэ хүний амийг аврах бодол байв. Бурхан түүнтэй хамт гэсэн баталгааг тэр мэдэрсэн болохоор тэр ямар ч айдсыг мэдэрсэнгүй. Тэр тээнэгэлзэлгүйгээр, аюулгүй байдалын төхөөрөмжгүй атлаа гал руу яаран орж түүнийг аварсан юм. -Чайнг “Тэр эмэгтэй зүгээр байгаад л би талархаж байна. Цагдаа хүн хийх ёстой зүйлийг л хийсэн. Үүнтэй адил нөхцөл байдалд байсан хэн ч гэсэн ийм зүйлийг хийх байсан юм,” хэмээн хүүрнэв.

Энэ бичлэгийг сонирхогчид доорхи сайт уруу http://news.kbs.co.kr/article/society/200910/20091008/1860981.html. орж үзнэ үү.

1996 онд Манмин Халамжийн Тосгон байгуулсанаас хойш, Ахлагч Хан Бюунгёонг (64) орон гэргүй, асрах ямар ч гэр бүлгүй өндөр настануудад өөрийн гэр бүлийн адилаар үйлчилэв. Тэр залуу байхдаа, Хан ахлагч бизнесээ өргөсгөхийг хичээж байгаад дампуурсан юм.

Манмин Төв Сүмд замчилагдахаас өмнө тэр хогийн саванд хаягдсан хоолны үлдэгдэлээр гол зогоодог байв. Түүнд амьдрах газар болон автобусын жолоочоор ажиллах боломжыг өгсөн Доктор И Жэе рок гээр дамжуулан, тэр Их Эзэний хайрыг мэдэрч, амьдралынхаа турш ядуу мөн хаягдсан хүмүүсийг халамжлахаар шийдсэн билээ. Ахлагч Хан хэлэхдээ, “Хэрэв би нэг л найдлагатай байвал, тэр найдлага бол- өөрөө туслуулсаны адилаар -өлсөж буй мөн ядуу хөршүүддээ туслах нь юм,” хэмээн хэлжээ.

Өөрийн цөхөрсөн амьдраллаа найдлагатай сайхан амьдрал болгосон гишүүд ч бас байгаа. Тэдний нэгэн нь Мүүн Дикон Квангсик юм. “Итгэлтэй хүнд бүх зүйл боломжтой,” гэсэн итгэх итгэлтэйгээр Мүүн 3 удаа алтан медалийг авсан. Тэр өнгөрсөн 9 сард Өмнөд Солонгосын Жеоннам Илвон Аймагт болсон 29 дэх Тахир Дутуу Хүмүүсийн Спортын Улсын Тэмцээнд 70 килограмын ангилалд шүүрэлт, өргөлт, мөн түлхэлттэй өргөлтийн ангилалт алтан медалийг хүртсэн билээ.

Долоон жилийн өмнө, Мүүн нүдний торлог бүрхэвчийн хар өнгөт үрэвсэлээс болж хараагаа алдсан билээ. Гэвч тэр хэлэхдээ, “Эцэг Бурхан Тэнгэрийн оронд миний биеийг төгс төгөлдөр болгох болно гэдэгт би итгэдэг. Би өөртэйгөө тэмцэхдээ заримдаа унадаг ч гэсэн, өөрийгөө бусадтай харьцуулахын оронд Бурханы надад өгсөн баяр баясгалан болон талархалаар би өөрийн амьдралыг дүүргэдэг,” гэж хэлсэн юм. Доктор И Жэе рук өөрийн захиасаар дамжуулан “үнэнээр амьдар” гэж бидэнд хэлэхэд түүгээр хүчийг авдагаа илчлэн хэлсэн билээ. Мүүн мөн талархаж байдаг нь манай сүмд явж эхэлснээс хойш түүний хараа муудахаа больсон. Өмнө харж чаддаггүй байсан ба Библи үсгүүдийг унших болсон юм.

Доктор И Жэе рукын захиасуудыг тэдний амьдралын луужин болсон гэж бүх гишүүд хүлээн зөвшөөрцгөөдөг билээ. “Сүмд л итгэмжит байх ёстой бус, харин өөрийн гэр бүл, ажил, очих газар бүртээ болон Бурханы өргөөнд хамаарагдах бүх газруудад итгэмжитэй байх хэрэгтэй.” Та нар эхлээд Бурханыг хайрлах хэрэгтэй, тэгээд хөршүүдээ өөрийн адилаар хайрлах хэрэгтэй, яагаад гэвэл энэ нь бидний төлөө Бурханы хүсдэг зүйл юм,” гэж Доктор И Жэе рук олон удаа онцлон хэлсэн юм.



Ахлагч Хан Бюунёонг (баруун талаас 2 дахь хүн) эхнэртэйгээ (халамжилагч И До Сөн) орхигдон хөршүүддээ үйлчлэн баяр баясгалантайгаар амьдарч байгаа байдал.



“Үсчингийн Номлол”ын гишүүд мөн номлолын багийн удирдагч болох И Малай сар болгон өндөр настануудын үсийг засаж байдаг.



Манмин Сүмийн Сайн Дурын Номлолын гишүүд мөн тэдний удирдагч Жунг Еүн Лэй, бүтэн сайн өдрийн цуглаанд ирэх тахир дутуу хүмүүст зориулсан тэрэгээр үйлчилэн тусалж байдаг.




Сүмд үйлчилэгч Мөн Кванг сик 3 удаа алтан медалийн эзэн болсон юм. Тэрбээр 2009 оны 9 сарын 21-25ны хооронд 29 дэхь Тахир Дутуу Хүмүүсийн Улсын Спортын Тэмцээнд 70 килограмын ангилалд шүүрэлт, өргөлт, мөн давхар өргөлтийн ангилалд алтан медал авжээ.

"Загалмайн сайн мэдээ"- ын цуврал" –(4)

# Библийг Зохиогч нь Бурхан

"Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай" (2 Тимот 3:16)



Доктор И Жэй руг

Эзэн Бурхан бол Сүнс болохоор бидний махан нүдэнд харагдашгүйн учир Тэр олон маягаар Өөрийгөө илчилдэг. Бурхан энэ орчинд бүх зүйлс, Түүний хүчээр эдгээлтийг хүлээн авсан хүмүүсийн гэрчлэл, мөн илүү ойлгомжтойгоор яривал, Библиэр дамжуулан Өөрийгөө илэрхийлдэг. Ийм учраас бид Библиэс уншихдаа, Бурхан хүмүүнийг бүтээсэн зорилгын тухай, хүн төрөлхтөний түүхийг захирах Түүний маягийн талаар, хүмүүний боловсруулах эхлэл мөн төсгөлийн тухай, Тэнгэр орон, Там, Бидний Аврагч Есүс Христ, мөн хүмүүний үүргийн талаар болох янз бүрийн сэдвийг дүрсэлдэг "авралын сургаал"-ыг бид дэлгэрэнгүй сурч чаддаг юм.

### *1. Библийн Зохиогч нь Бурхан*

Библи 66 номоор бүтдэг: Хуучин Гэрээнд 39-н ном, Шинэ Гэрээнд 27-н ном байдаг. 1,600 жилээр (Хуучин Гэрээ 1,500 жил мөн Шинэ Гэрээ 100 жил) Библийг 34 хүн дамнадаг. Хуучин Гэрээг 26 хүн мөн Шинэ Гэрээг 8 хүн бичсэн гэдэг нь мэдэгддэг. 34 тусдаа хүн Библийг цэдэглэсэн боловч, тэднээс нэгээхэн ч үүний "зохиогч" байсангүй; Тэд бүгд орлон бичигчид байв.

Нэгэн ээж 2 хүүтэй байж мөн бага хүүдээ захиа бичихийг хүсч байлаа гэж бодьё. Хэрвээ тэр захиагаа мөн хэлэхийг хүсч буй зүйлсээ том хүүгээрээ бичүүлэх юм бол, энэ нь хэний захиа байх вэ? Том хүү нь энэ захиаг "бичсэн" боловч, энэ захиа ээжээс нь ирж байгаа юм. Үүний адилаар, Эцэг Бурхан Өөрийн мэлмийд зохистой хэд хэдэн хүнийг Ариун Сүнсний онгодоор Библийг цэдэглэхээр дуудаж мөн удирдсан юм.

Үүний талаар 2 Тимот 3:16, "Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай," гэж хэлсэн юм, мөн 2 Петр 1:21, "Учир нь нэг ч эш үзүүллэг хэзээ ч хүний хүслээр гарсангүй, харин Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүс Бурханаас айлджээ," гэж бидэнд сануулдаг.

Исаиа 34:16 ч бас, "Эзэний номноос олоод уншигтун. Тэдгээрийн нэг нь ч алга болохгүй, нэг нь ч ижлээ алдахгүй. Учир нь Түүний ам айлдаж, Түүний Сүнс тэднийг цуглуулсан юм," гэж хэлдэг.

Учир нь Бүхнийг Чадагч Бурхан Библийг Ариун Сүнсний онгодоор бичүүлсэн. Библи олон хүнээр бичигдсэн ч гэсэн өөртэйгөө зөрчилдсөн биш харин нэг хүн бичсэн мэт уялдаатай байдаг.

### *2. Библи Ариун Сүнсний Онгодоор Цэдэглэгдсэн нь*

Библи Ариун Сүнсний онгодтойгоор цэдэглэгдсэний учир, энэ нь Ариун Сүнсний онгодоор ойлгогдох ёстой. Эгэл хүний бодлоор Библийг ойлгохийг хичээх нь хүмүүсийг мөхөлийн зам уруу чиглүүлэх болно. Яагаад гэвэл тийм ойлголт Бурханын хүсэлд нийцэхгүй байж магадгүй (2 Петр 3:16). Харин энэ нь Ариун Сүнсний онгодоор ойлгогдоход, Библиэс ямар ч ишлэл илжээ алдахгүй гэж бид нар сурдаг (Исайа 34:16). Зүүлт хийхийн тулд нэгээс илүү сувд байх ёстойн адилаар, ишлэл ижлээ олж мөн бие биентэйгээ хослоход Библийн сүнслэг утга нь тайлбарлагдаж чадна.

Жишээ нь: Үйлс 2:21, "Эзэний нэрийг дуудсан бүхэн аврагдах болно," гэж айлдсан. Авралын талаар Бурханы хүсэл энэ ишлэлээр хангалттайг тайлбарлагдаж чаддаггүй. Матай 7: 21нд Их Эзэний бидэнд хэлснээр, "Эзэн минь Эзэн минь гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцгийн хүслийг биелүүлдэг хүн орно." Бурханы нэрийг дуудах нь авралыг хүлээн авах нөхцөлүүдийг хангаж чадахгүй юм. Ром 10:10 дээр бидэнд сануулдагчлан, "Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ." Зөвхөн зүрх сэтгэлээрээ итгэдэг мөн зөв шударга байдалд үйлддэг хүмүүс авралыг хүлээн авч чадна.

Тэгвэл "зүрхэндээ итгэх" гэж юу гэсэн үг вэ? Иаков 2:14, "Ах дүүс минь хэрэв хүн "Надад итгэл бий" гэсэн атлаа үйлсгүй бол ямар ашигтай юм бэ? Тийм итгэл түүнийг аварч чадна гэж үү?" гэж айлдсан юм. Хүн зүрхэндээ итгэж мөн зөв шударга байдалаар илэрхийлэгдэхэд, тэр хүн гэм нүгэлийг хаяж мөн Бурханы үгээр амьдрахыг зүтгэдэгийг бид хардаг.

Ром 3:28, "Учир нь хүн Хуулийн үйлсээс ангид, итгэлээр зөвтгөгддөг гэж бид үздэг," гэж хэлдэг. Хичээнгүйгээр, хичнээн үнэнээр амьдарч байсан ч гэсэн, хэрвээ таны үйлс итгэлээр ирдэггүй бол, үйлсээрээ зөвтгөгдөж чаддаггүй юм. "Зүрхэндээ итгэх" нь юу гэсэн үг вэ гэхлээр ариусгагдсан зүрх сэтгэлээс болж ариун ааш авиртай болно, өөрөөр хэлбэл зүрх сэтгэлийн хөвч хөндөлтийг (ухаарал, гэмшил) гүйцэтгэх юм.

Бурханы нэрийг амаараа хүлээн зөвшөөрч, Бурханы сургаалаар амьдарч, мөн зүрхэндээ итгэхдээ зүрх сэтгэлийн хөвч хөндөх итгэгчидэд аврал зориулагдсан байна. Библийн ишлэлүүдийн ижлийг олохгүйгээр хүмүүс үнэнийг буруугаар сурч мөн "аврагч Есүс бол өөрийнх нь Аврагч гэдгийг хүлээдэг хүн болгонд зориулагдсан" эсвэл "итгэх л юм бол, нүгэлдээ амьдардаг ч гэсэн хэвээрээ авралыг хүлээн авч чадна" гэж бодож магадгүй. Ийм буруу ойлголт хүмүүсийг нүгэл рүү, мөн яваандаа мөхөлд чиглүүлэх болно.

Библийн ишлэлд агуулгадсан Бурханы хүслийг мөн тэдний бүрэн сүнслэг чухалыг зөвөөр ойлгохын тулд, та нар тэдний ижилийг олж мөн тэднийг Ариун Сүнсний онгодтойгоор ойлгох ёстой.

### *3. Бурхан Үг, Мөнхийн Үнэн*

Библи бол Бурханы Үг мөн түүнд бичигдсэн бүх зүйлс үнэн юм. Израиль улсын түүх шиг үйл явдалууд, түүний хажууд байдаг улсууд, хүмүүсийн мөн газруудын нэрс, ёс уламжлалт, энэ бүгд Библийн үнэнийг гэрчилдэг.

Тэднээс хамгийн чухал нь Библи Есүсийн талаар байгаа янз бүрийн эш үзүүллэгүүдийг багтаадаг. Хуучин Гэрээнд Есүсийг төрөх, тэнгэрийн хаанчлалыг тунхаглах, үхэл, дахин амилалтын тухай Бурханы эш үзүүллэгүүд байгаа, харин Есүс хэрхэн Хуучин Гэрээний эш үзүүллэгүүдийг биелүүлсэний талаар олон түүхүүд мөн цэдгүүд Шинэ Гэрээнд байдаг юм.

Есүсийн төрлийн тухай, Эхлэл 3:15нд Бурхан Аврагчийг Израилийн хүмүүст төрнө гэдгийг урьдаас хэлсэн. Эзэн Бурхан могойг зүхэхдээ, Тэр, "Би чамайг тэр эмэгтэйтэй өс хонзонтой, бас чиний үр хүүхдийг тэр эмэгтэйн үр хүүхэдтэй өс хонзонтой болгох болно. Тэр эмэгтэйн үр хүүхэд чиний толгойг няцалж, чи түүний өсгийг няцлах болно," гэж хэлсэн.

Энэ хэсэгт "эмэгтэй" нь сүнслэг байдлаар Израилийг төлөөлж байна. Жам ёсоор эмэгтэй хүн хүүхдийг төрүүлдэг, гэхдээ "эмэгтэй" мөн "түүний үр хүүхэд"-ийн талаар тодорхойгоор ярьснаараа Эцэг Бурхан энэ ишлэлд агуулгадсан сүнслэг чухалынх нь тухай илэрхийлж байна. Илчлэлт 12:5, "Тэр эмэгтэй бүх үндэстэнийг төмөр таягаар захирах эрэгтэй хүүхэд төрүүлэв. Хүүг Бурханд, Түүний сэнтий өөд аваачлаа," гэж. Энэ ишлэл Израилийн хүмүүсийн дунд төрсөн Есүс Христийг ч бас гэрчилдэг билээ.

Исаиа 7:14, "Тийм учраас Эзэн Өөрөө чамд нэгэн тэмдэг өгнө. Үзэгтүн! Нэгэн онгон бүсгүй хүүхэдтэй болж, хүү төрүүлээд, Түүнийгээ "Иммануел" гэрж нэрлэнэ," гэж айлдагдсан. Мика 5:2, "Харин Бетлехем Ефрата аа, хэдийгээр чи Иудайгийн бүлгүүдийн дунд өчүүхэн ач, Миний төлөө Израилийг захирах Нэгэн нь чамаас төрөн гарах болно. Энэ нь эртнээс хийгээд мөнхөөс үүдэлтэй," гэж хэлдэг. Энэ бошиглолуудын дагуу, Есүс Ариун Сүнсээр мөн тэжээлийн тэвшинд Онгон бүсгүй Мариагаас төрсөн. Зехариа 9:9-д урьдаас хэлснээр, "Есүс Иерусалимд орохдоо, Илжигний унага болон дудран" унасан. Дуулал 41:9 дээр хэлсэнчлэн, Есүсийн амийн талхинаас нь иддэг байсан өөрийн дотно найз болох Иудас Искариот түүнээс урвасан.

Тэгээд түүний үхэл, оршуулага, дахин амилалт, мөн дээшээ одсны талаар нь, Хуучин Гэрээний Исаиа, Дуулал, Зехариад зөгнөгдөн номнуудад тоолшгүй олон дэлгэрэнгүй бичигдсэн байдаг. Мөн энэ бүхэн Шинэ Гэрээний үед биелэгдсэн юм.

Библи үнэхээр Бурханы Үг юм, мөн амласнаараа, Тэр үнэхээр үүнд итгэж мөн үүний дагуу амьдардаг хүн болгоныг адислах болно. Жишээ нь: Есүс Марк 9:23 дээр айлдахдаа, "Хэрэв Та чаддаг юм бол гэв үү? Итгэлтэй хүнд бүх юм боломжтой," гэж хэлсэнчлэн, төгс төгөлдөр итгэлтэй хүмүүст боломжгүй зүйл гэж үгүй.

Мөн Египетээс Гарсан нь 15:26-д хэлсэнчлэн, бид гэм нүглээс холдож мөн бүрнээр Бурханы зарлиг тушаалуудыг дагахад маань ямар ч өвчин биднийг хэзээ ч тарчилж чадахгүй. Түүний зарлиг тушаалуудыг дагаж чадахгүй байснаараа өвчинд автагдсан ч гэсэн, Бурхан, бидний хооронд буй нүглийн ханыг бид наманчлалаар устгах үедээ Бурханы хүчээр эдгээлтийг хүлээн авч чадна.

Христэд итгэгч Ах Эгч нар минь,

Сургаалт Үгс 8:17 дээр Түүний хэлсэнчлэн, "Намайг хайрлагсдыг би хайрлана. Намайг хичээнгүйлэн хайдаг нь намайг олно." Та нар Бурханы зарлиг тушаал бүрээр амьдарч, хичээнгүйлэн дагахад чинь, Бурхан та нартай үргэлж уулзаж, адислаж, мөн Шинэ Иерусалимд та нарыг цуглуулах болтугай гэдгийг би Эзэн Есүс Христийн нэрээр залбирч байна!

Монгол Манмин сүм байгуулагдсаны 7жилийн

Монгол Манмин сүм байгуулагдсаны 7жилийн ойн баярт зориулсан үйл ажиллагаа болон "Эрх мэдэлт хүч" өврийн алчуурын цуглаан явагдах болно. Амийн сургаал үгс тунхаглагдаж жинхэнэ Бурханы Эрх мэдэлт хүч болон энэрэл ивээлийг хүртэх боломжтой онцгой талбар!

♦ 2010оны 5сарын 1 ний 14 цагт. (Эрх мэдэлт өврийн алчуурын цуглаан)
2010оны 5сарын 2 ны 10 цагт. (Ойн баярын нээлт)
♦ Байршил: Монгол Манмин сүм.
♦ Номлогч: Жү Хён Гуон -Манмин төв сүмийн дэд пастор (БНСУ)
♦ Утас: 9117-0773 / 5525-7637

Манмин Мэдээ
Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-3донг, Гуро-гу, Сеүл,
152-848 Солонгос Улс
Утас: 82-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин



# "Эзэнээс холдсон Европчуудыг Эцэг Бурханд буцан хөтөлж байна"

## Номлолын Тайлан: Бельгийн Брюссельд жилийн турш Европын Номлолын Суурийн Хадыг тавьсан тайлан

Номлогч Христина Ро (Брюсселийн Манмин Сүм; Бельгийн Номлолын Төв)

### ♦ Бурханы Тавьсан Суурин дээр Европын Номлолыг Сүлжээ тавигдсан

Европын Холбооны төв, Брюссель, нь Баруун Европын төвд байдаг олон улсын хот юм. Энэ хотоос Европын аль ч хот уруу нисэх онгоцоор 3 цагийн зайтай зайтай байдаг. Би энэ хотод амьдардаг. Брюссельд буй Европын номлолын сүлжээг байгуулах нь миний үндсэн зорилго юм. Одоогоор арван улсын 50 сүмүүд холбогдоцгоосон байна. Энэ нь үнэндээ гайхалтай зүйл юм. Тэд өөрсдийгөө жинхэнэ Христийн дагалдагч гэж боддог болохоор Ази эмэгтэй хүний хувьд тэдний анхааралыг татахад хэцүү. Харин бүх сүмүүдээс 60% нь Доктор Жаерок Леегийн товхимолууд аль хэдийнээ таньсан учраас боломжтой байв. Тэдний олонх нь бичлэгээр Доктор Леегийн гадаадад хийсэн номлолуудыг үзсэн. Номлолууд нь бүгд ариун байдлын сургаал мөн хүчний товхимолуудыг өгүүлж байсан бөгөөд тэд өврийн алчуурт залбиралын тухай мэдлэгтэй байв. (Үйлс 19:11-12).

Нэгэн удаа ийм үйл явдал тохиолдсон юм: Би нэгэн Пастортай танилцаад түүнд Доктор И Жэе рукын ном Миний Амьдрал, Миний Итгэл мөн "Бурханы Эрх мэдэлт Хүч"гэгч DVD-ийг өгсөн. Хоёр хоногийн дараа би түүнээс е-шуудан авав. Захидалдаа бичихдээ тэр," Энэ номыг уншихдаа Ариун Сүнсээр хөтлөгдсөн билээ. Бурханы хүчирхэг үйлсүүд тохиолдож буйг мэдэрсэн учраас би сэтгэл хөтлөн уйлахаа больж чадаагүй юм," гэж хэлсэн байв.

Доктор Жаерок Леегийн номнууд мөн "Бурханы Эрх мэдэлт Хүч" DVD-нь Пасторуудад маш ихээр тараагдахад 100-200-н Пасторуудад- Европын номлолын байнгын холбоо байгуулагдав.






Мансууруулах бодисын донтолтоос эдгээгдсэн нэгэн ах дээр очиж алчуурт залбиралыг хийж өгсөн нь



Францын Ариун Бурхан ТВ шууд дамжуулагдсан айлдварыг номлосон нь

2003 онд би Канаан Номлолын 3 дахь бүлгийн зохион байгуулагч гэх Бурханаас өгөгдсөн энэ үүргийг биелүүлж байсан боловч, итгэл маань зогсонги байсныг ухааран эрч хүч олохыг хүсэв. Пастор И Дебора, ММТС (Манмин Номлолын Бэлтгэх Төв)-ийн Ерөнхий Захирал намайг Непальд болох номлолд түр хугацаанд оролцохыг санал болгосон. Иймд тус жилийн 9 сарын үед Непальд очив. Номлолын аялалын дараа ч гэсэн, би Непаль хүмүүсийн зүрх сэтгэлийг мартаж чадаагүй юм. Тэд Бурханы жинхэнэ хүүхдүүдийн эрх мэдлийг эдэлж чадахгүй байсан нь надад харамсалтай байв.

2004 оны 7 сараас хойш ММБТ-д Даргын Туслахаар ажиллаж байхдаа дэлхий даяар номлолын чухалыг ухаарав. 2005 оны 1 сард Европын сайн мэдээ тараах аялалд оролцов. Бид Бельгид буй нэгэн сүмд очиж тэнд эхний цуглаанд суув. Энэ цуглаанд ямар ч сургаал байгаагүй. Тэд цагийн турш магтаал дуу дуулсаны дараа Пастор нь индэр дээр гарч ирэн 5 минутын турш ярив. Тэгээд цуглаан нь дуусав. Үүнийг үзээд би маш их харамсав. Миний хувьд мартагдашгүй зүйлсийн нэг бол гишүүдийн нэг нь магтаал дууны дундуур сөгдөөд уйлж эхэлсэн юм. Энэ хүн Бурханыг чин сэтгэлээсээ өгүүлж байсан ба мөн сүнсээр цангаж байсан билээ. Тэр Их Эзэнтэй уулзмаар байсан ч тэр замаа олж чадаагүй юм.



Финландын "Эрх Чөлөө"-ний сүм дээр магтаалыг бэлтгэж буй хүмүүстэй нөхөрлөж байгаа.

### ♦ Ариун Байдлын Сургаал, Бурханы Хүчээр Сүмүүд болон Пасторууд өөрчлөгдөж буйг харах нь

2006 оны 5 сард 2 дахь удаагаа Европ уруу аялалаар явав. Анхны сайн мэдээ тараах аялалаар явахад бидний очсон сүм дээр дахин очиход бид тэр сүмийг бүр мөсөн өөрчлөгдсөнийг харав. Пастор нь Тэргүүн Пасторын ном болох Иобын Номноос сургаал айлдаж байсныг би харав. ММБТ-ийн өнгөрсөн аялалаас хойш энэ пастор Доктор И Жэе рук номыг орчуулж эхэлснээс энэрэл хүртэх болсон. Тэр ариун сургаалаар гишүүдээ удирдан, өөртөө итгэх итгэл мөн баталгааг авсан. Энэ сүм бол Брюсселийн Манмин Сүм (Пастор Гая Давидс).

ММБТ-ийн даргын туслахаар би байнга үүнийг бодсон: "Дэлхий даяар энэ ариун байдлын сургаалыг олон сүмүүдэд мөн пасторуудад хэн түгээх вэ?" мөн "Тэднийг сэрээх номлогч хэн байх вэ?"

### ♦ Сургаалыг Түгээх Хэрэгтэйг Мэдэрч мөн Дэлхий Даяар Номлох Дуудлагыг Авсан нь

Нэг жилийн дараа би бизнесийн хэргээр дахиад Европ руу айлчилав. Намайг ариун байдлын сургаалыг мөн Тэргүүн Пастороар дамжуулан Бурханыг илэрхийлсэн хүчирхэг үйлсийг танилцуулахад минь, олон пасторууд мөн Христийн хүмүүс өөрчлөгдсөн. Би зүрх сэтгэлдээ баталгааг мэдэрсэн.

"Аав аа, бэлтгэгдсэн номлолч үгүй бол, намайг Европ уруу явуулаарай."

Тэр цагаас хойш, би номлогч болохоор бэлтгэж мөн номлогчоор явна гэдгээ Тэргүүн Пастор мөн сүмд мэдэгдэв. Ариун урсгалын сургаал байгаа учир хүн төрөлхтөнийг замчилж чадна гэх итгэл төрсөн.

Намайг номлогч болох болзол хангагдсаны дараа 2008 оны 6 сард томилогдохоос 6 сарын өмнө Бурханы хариултуудыг хүлээн авах цаг болсон байсан. Намайг залбирч байхад Ариун Сүнс миний бүх зүйлсийг баталгаатайгаар бэлтгэхээр чиглүүлсэн юм.

"Энэ нь хийхэд хэцүү" гэж би ер боддоггүй. Учир нь гэвэл Европын Авралын зар нь Бурханы тавьсан суурин дээр гүйцэгдэж байгаа юм.

Номлол биднийг ганцхан Бурханы үгтэй бус, харин Бурханы хүч хамт байхыг шаарддаг. Тэргүүн Пастороар дамжуулан илэрхийлэгдсэн хүчтэй үйлс ч бас бидэнд байгаа. Би бэлтгэгдсэнийхээ хирээр Бурханы хүчийг илэрхийлж чадна.

Та нар яагаад хэрэгсэлүүдийг бэлтгэж мөн Есүс Христийн тавьсан суурин дээр дэлхийн номлолыг гүйцэлдүүлэхгүй байна вэ?

## Манмин Сүмийн Орос Дахь Товхимолууд



Пастор Владмир Осиров
(Оросын Есүс Христийн Ариун Байдлын Сүмийн Тэргүүлэгч Санкт Петр бургын Манмин Сүм)

Өнгөрсөн 20 жилийн туршид Оросд олон өөрчлөлтүүд байсан юм. Хүмүүс хуучин зүйлсийг хаяад мөн шинэ ба сайн зүйлсийг олохыг эрэлхийлцгээж байв. Дагах сайн жишээнүүдийг олж чадахгүйгээр тэд өөрсдийн бодож буй зүйлсийг сайн мөн үнэн гэж үздэг. Христийн хүмүүс ч гэсэн жинхэнэ үнэнийг мэдэхгүй байвал бусад шашнуудын зөв гэж үздэг зүйлсийг зөвшөөрдөг.

Орчин үед олон Орос залуучууд ааш авирт нь ямар муу нөлөөтэй болохыг бодолгүйгээр үйлддэг. Тэгээд тэд хүссэн зүйлсээ даруй авмаар, мөн хүссэн зүйлсээ даруй эдэлмээр байдаг. Улс төр эсвэл сургууль тэдний төлөө үүрэг хүлээх хэрэгтэй гэж тэд боддог. Тийм учраас тэднээс олонх нь адилхан зорилгоор сүмд зочилж ирдэг. Тэд доторх асуудлуудаа таниулж, сэтгэлээ тайвшруулцгаая гэсэн хүслээр сүм дээр ирдэг. Сүмийн гишүүд ч тэдний зүрх сэтгэлийг ойлгохыг хичээхээс биш бусдаар бол энэ залуучуудыг сүмийн амьдралд дасгаж чадахгүй юм.

Зөвхөн ариун байдлын сургаалаар тэд өөрчлөгдөж чадна. Тэд залбирал мөн шүтлэгийн үйлчилгээнүүдэд очдог шиг Христийн амьдралын үндсэн утга учир үйлддэггүй, тэд Бурханы тухай мэдэн мөн үгийн дагуу амьдруулан жолоодох нь чухал юм. Ариун байдлын сургаал нь үгийн дагуу амьдрахыг тэдэнд тодорхойгоор зааж чаддаг. Сүм маань хуучин зүйлсийг хаяснаараа ариусгалыг өгүүлж мөн үүний төлөө чин сэтгэлээсээ залбирч байгаа. Манмин Сүмд миний үзсэн хамгийн гайхалтай зүйлсийн нэг бол гишүүд нь бүх зүйлээ залбиралаар эхэлдэг. Орой болгон манай сүмийн гишүүд цугларч залбирдаг болсон.

Коммунизмын 70 жилийн захиргаадалтын улмаас одоог хүртэл Орост Бурханы эсрэг зогсдог. Тийм учраас олон номлогчид мөн их залбирал энэ улсад хэрэгтэй байна. Тиймээс, Оросын Манмин Номлолын Төвд 8,000 номлогчдыг сургах зорилготой байгаа. Номлогчдоор дамжуулан ариун байдлын сургаал Орос даяар тарж, мөн олон итгэгч нар Их Эзэнд замчилуулах болно.

* Энэ бол ММБТ-ийн 2009 оны 12 сарын 14-ний 20 дахь ангид зориулсан онцгой лекцийн хураангуй юм.